



102

ТӨРИЙН ӨМЧИЙН 6 ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛУУДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/184, А/220, А/02
А/170, А/161, А/211

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11 дахь заалт, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн "Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичиг"-ийн 2.4.1, 2.4.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Суралцагч бусад их сургуулиас хичээл судлах үйл ажиллагааг зохицуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг "Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичиг"-т хамаарах сургуулиуд санамж бичгийн хэрэгжих хугацаанд мөрдөн ажилласугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Монгол улсын Их сургуулийн Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Д.Бадмаанямбуу/, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал /Х.Энхжаргал/, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Боловсрол хариуцсан дэд захирал /Г.Батбаатар/, Монгол улсын Боловсролын их сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал /Х.Тамир/, Соёл урлагийн их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал /Д.Одсүрэн/, Хөдөө аж ахуйн их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал /Р.Чанцалдулам/ нарт үүрэг болгосугай.

АШУУИС-ИЙН ЗАХИРАЛ

Н.ХҮРЭЛБААТАР

МУИС-ИЙН ЗАХИРАЛ

Б.ОЧИРХУЯГ

ХААИС-ИЙН ЗАХИРАЛ

Т.ХЭРҮҮГА

МУБИС-ИЙН ЗАХИРАЛ


О.АЛТАНГОО

ШУТИС-ИЙН ЗАХИРАЛ

Б.ОЧИРБАТ

СУИС-ИЙН ЗАХИРАЛ

Э.СӨНИНТОГОС





**СУРАЛЦАГЧ БУСАД ИХ СУРГУУЛИАС ХИЧЭЭЛ СУДЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Суралцагч нь өөрийн суралцаж буй сургуулиас гадна төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичигт дурдагдсан бусад их сургууль (цаашид “их сургууль” гэнэ)-иас тодорхой түвшний суралцахуйн үр дүнг эзэмших зорилгоор хичээл сонгон судлах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичигт дурдагдсан сургуулиуд энэхүү журмыг мөрдөнө.

2. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Их сургууль: Төрийн өмчийн их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичигт дурдагдсан сургуулиуд;
- 2.2. Их сургууль хооронд хичээл сонгон судлах: Нэг их сургуулийн суралцагч өөр их сургуулийн хичээлээс сонгон суралцах үйл ажиллагаа;
- 2.3. Илгээгч их сургууль: Суралцагчийн үндсэн харьяаллын сургууль;
- 2.4. Хүлээн авагч их сургууль: Суралцагчийн сонгон судлах хичээлийн харьяа сургууль;
- 2.5. Хичээл солилцооны систем: Суралцагч судлах хичээлийн санал гаргах, илгээгч болон хүлээн авагч их сургуулиудын зөвшөөрлийг бүртгэх, хичээл солилцоотой холбоотой журам, зарлал, мэдээллийг түгээх цахим систем;

3. ИХ СУРГУУЛЬ ХООРОНД ХИЧЭЭЛ СОНГОН СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1. Суралцагч нь дараах зорилгоор өөр сургуулиас хичээл сонгон судалж болно.
 - 3.1.1. Өөрийн хөтөлбөрт туссан тодорхой хичээлийг дүйцүүлэх (цаашид “дүйцүүлэх” гэнэ);
 - 3.1.2. Өөрийн хөтөлбөрийн чөлөөт сонголтын эсвэл бусад нэгжээс судлуулахаар тодорхойлогдон тодорхой хичээлийн нэр заагаагүй багцын биелэлтэд тооцуулах (цаашид “багцад тооцуулах” гэнэ);
 - 3.1.3. Өөрийн хөтөлбөрийн биелэлтэд тооцуулахгүй ч өөрийн мэдлэг, чадвараа нэмэгдүүлэх (цаашид “нэмэлтээр судлах”);
- 3.2. Дүйцүүлэх зорилгоор өөр сургуулиас хичээл сонгон судлах тохиолдолд “Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг дүгнэх, дүйцүүлэхэд баримтлах үлгэрчилсэн журам”-д туссан дүйцүүлэх хичээлд тавигдах шаардлагыг хангасан байна. Уг шаардлагыг хангасан буюу дүйцүүлж болох тухай дүгнэлтийг харьяалах нэгжийн тэнхим тодорхойлно.